

# Үнээний ургийн бичиг

Ардын аж ахуйтан Жон шинэ үхэр сүрэг худалдан авахаар шийджээ. Энэ шинэ сүргийн үнээ бүр нь 2 ихэр төл гаргадаг. Үхэрнүүдийн ургийн бичиг нь нэг болон түүнээс олон  $N$  ( $3 \leq N < 200$ ) зангилаа бүхий 2-тын модоор илэрхийлэгдэх боломжтой. Мод нь дараахь шинж чанартай:

- Зангилаа бүрийн зэрэг нь 0 эсвэл 2. Зэрэг нь тухайн загилааны хүүхдүүдийн тоо.
- Модны өндөр нь  $K$ -тай тэнцүү ( $1 < K < 100$ ). Модны өндөр нь модны үндсээс навчнууд руу явах замнуудын хамгийн урт зам. Хүүгүй зангилааг навч гэнэ.

Хэдэн янзын ургын мод үүсэж болох вэ? Хэрвээ модны бүтэц нь өөр бол ургын модыг ялгаатай гэж үзнэ. Нийт үүсч болох ялгаатай ургын моднуудын тоог 9901-д хувааж үлдэгдлийг ол.

**Програмын нэр: pocows**

**Оролтын формат**

1-р мөр: Зайгаар тусгаарлагдсан 2 бүхэл тоо  $N$ ,  $K$ .  $N$  - нийт зангилааны тоо.  $K$  - модны гүн.

**Жишээ оролт (файл pocows.in)**

5 3

**Гаралтын формат**

1-р мөр : Нэг ширхэг бүхэл тоо. Нийт үүсч болох ургын модны тоог 9901-д хувааж гарсан үлдэгдэл.

**Жишээ гаралт (файл pocows.out)**

2

**Гаралтын талаар**

5 зангилаатай 3 гүнтэй мод 2 янзаар байж болно. Эдгээр нь:

```
  @          @
  /\         /\
 @ @ болон @ @
  /\         /\
 @ @          @ @
```

Орчуулсан : Б.Даваабаяр